



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020.04.29.

№ 01

Улаанбаатар хот

Компанийн санхүүгийн тайлан, түүнд
хийгдсэн хараат бус аудитын
дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт,
Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа
эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд
хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

Хурлын дарга: /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2020. 04. 29

№ 02

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны
тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагааны талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

Хурлын дарга: Э.ТРАНС / Ч.Амарсанаа /





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020. 04. 29

№ 03

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
2. Төлөвлөгөөнд дурьдагдсан ажлуудыг чанартай хийж гүйцэтгэх, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал / Ч.Амарсанаа/-д даалгасугай.

Хурлын дарга: Ч.Амарсанаа /





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020. 04.29.

№ 04

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны
тайлан, санхүүгийн тайлангийн талаар
ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт,
Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа
эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан,
санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ын дүгнэлтийг хангалттай гэж
үзсүгэй.
2. Үйл ажиллагааны төлөвлөгөө, гаргасан зөвлөмжийн гүйцэтгэлд анхаарч
ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

Хурлын дарга: / Ч.Амарсанаа /





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020. 04.29.

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат гишүүдээр
 - 1) Данзан ДАЯНБИЛГҮҮН
 - 2) Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ
 - 3) Шараа ШИНЭБАЯР
 - 4) Чулуун АМАРСАНАА
 - 5) Чулуун ЭНХБОЛД
 - 6) Энхболд БАТБОЛД
2. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
 - 1) Алтангэрэл ЦЭНГЭЛ
 - 2) Чулуунбаатар ОРГИЛ
 - 3) Жаргалсайхан ЭНХТУЛГА нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

Хурлын дарга: / Ч.Амарсанаа /





Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2020. 04. 29

№ 06

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг 4,560,000 төгрөгөөр тогтоосугай.

Хурлын дарга: Ч.Амарсанаа /





**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2020. 04. 29.

№ 07

Улаанбаатар хот

Компанийн ногдол ашиг тараахгүй тухай

“Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас
ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс танилцуулсан Ногдол ашиг хувиарлахгүй байх шийдвэрийг зөвшөөрсүгэй.

Хурлын дарга: Ч.Амарсанаа /



**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020.04.29

Улаанбаатар хот

“Э-Транс ложистикс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 сарын 29-ны өдөр “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн хурлын танхимд 10 цагаас эхлэв.

Дэгийн дагуу тооллогын комиссын ирцийн тогтоол танилцуулав.

“Э-Транс ложистикс” ХК нь нийт саналын эрх бүхий 46,200,000 ширхэг хувьцаатай.

Нийт саналын эрх бүхий хувьцааны 93,49% буюу 43,194,517 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч (Үүнээс 14,976,838 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар, 28,217,679 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр) бүрэлдэхүүнтэйгээр хурал эхлэв.

Онлайнаар хурал зохион байгуулах болсонтой холбоотойгоор бичиг баримттайгаа компани дээр ирж гарын үсэг зурж ирцээ баталгаажуулсан хувьцаа эзэмшигчдийг хуралд саналын хуудсаар бус өөрийн биеэр оролцсонд тооцов.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- a. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
- b. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- c. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- d. ТУЗ-ийн 2020 оны цалин урамшууллын төсөв батлах
- e. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- f. Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах

Компанийн Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

Хурлаар хэлэлцэх асуудлуудын дагуу компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, 2020 оны төлөвлөгөө зэрэг компанийн нөхцөл байдлыг танилцуулав.

Компанийн ерөнхий нягтлан бодогч Э.Ариунтуяа:

Компанийн 2019 оны санхүүгийн тайлан түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийг танилцуулав.

Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Ганбат:

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг уншиж танилцуулав.

Компанийн Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа:

Хэлэлцэх асуудлын дагуу ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох, ТУЗ-ийн 2020 оны цалин урамшууллын төсөв батлах, Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулав.

Хэлэлцсэн асуудалуудтай холбогдуулж хувьцаа эзэмшигч БиДиСек ХК-нийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д.Даянбилгүүн:

Сүүлийн үеийн мэдээлэл өгөөч. Хойд талд байдаг шилжүүлэн ачих төвийн үйл ажиллагаа хэр явж байгаа вэ? Одоо урагшаа нүүрс, жонш гэсэн ачаанууд гарч байгаа юу? Улсын үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалттай хийгдэж байгаа төвийн үйл ажиллагаа хэр байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа: Төмөр замын хойд талын буюу Чоно группын авсан гээд байгаа хуучин МЧ-3-ын талбай дээрээс нүүрс бага хэмжээгээр явж байгаа. Жонш бол явахгүй байгаа учир нь Хятадууд орж ирж чадахгүй байгаа учраас. Шинэ төвийн хувьд бол бидний авагдсан мэдээгээр бол одоогоор ажиллах боломжгүй байгаа гэсэн түрээслэх болон ашиглуулах гэсэн яриа хөөрөө гараад тэр нь болохгүй байгаа гэж ойлгож байгаа.

Д.Даянбилгүүн: Тэгэхээр манай үүргийн худалдаачид болон имдорт хийж байгаа хүмүүс бараагаа татаж авч чадахгүй байгаа гэж үзэж болох уу. Агуулахаа ашиглаад тэдний барааг оруулж ирж хадгалаад дамжуулаад явуулж байх боломжтой юу?

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа: Ер нь бол өргөн хэрэглээний бараа оруулж ирж байгаа хүн хар одоо бол байхгүй байна. Манай хажуу талын Дардан ложистикс гэсэн компани 4 бүхээгтэй машинтай тэднийх бага сага явуулж байгаа байх манайх яг тийм зориулалтын машингүй бас дээр нь зөвшөөрөл энэ тэр гээд байдаг болохоор судалсан зүйл байхгүй байна.

Д.Даянбилгүүн: Машинтай нэг хүн байна л даа 10 машинтай гэсэн. Тэр тээврийн хэрэгслийг ашиглаад өөрийнхөө агуулахаар ачаа барааг нь дамжуулдаг тийм бизнесийг л хийвэл өнөөдөрийн энэ өвчний үел боломжтой юм шиг санагдаад байгаа юм. За тэгээд хуралд оролцогчдод амжилт хүсье.

Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа: Хувь хүмүүс бол бараагаа цуглуулаад явж байгаа л байх гэхдээ цаанаа түнштэй байдаг. Яг ложистикийн хүрээнд ийм ажил хийхэд хүндрэлтэй байна. Өөрийнхөө хэмжээнд энэ асуудлыг судлая.

Хувьцаа эзэмшигчдийн асуулт хариулт, санал хэлэх үйл ажиллагаа дуусч санал хураах үйл ажиллагаа эхлэв.

Тооллогын комисс хурлын шийдвэрийг танилцуулав.

Санал хураалтаар нийт хувьцааны 93.49% буюу 43,194,517 ширхэг хувьцаа эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигч саналын хуудас бөглөн өгсөн.

Хэлэлцэх асуудал 1:

1. Саналын хуудсаар Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,194,517 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
43,194,517	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 2:

2. Саналын хуудсаар Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,194,517 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00% татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
43,194,517	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 3:

3. Саналын хуудсаар Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,194,517 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
43,194,517	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 4:

4. Саналын хуудсаар хуудсаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны цалин урамшууллын төсөв тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,194,517 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0.00 % татгалзсан, 0.00 % түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
------------	--	------------	--	------------	--

Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
43,194,517	100%	0	0.00%	0	0.00%

Хэлэлцэх асуудал 5:

5. Саналын хуудсаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 43,194,517 ширхэг хувьцаатай 5 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй саналын хуудсаар:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

	ТУЗ-ийн ердийн гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Э.Батболд	8.9132%	23,100,100
2	Ч.Энхболд	8.9132%	23,100,100
3	Ч.Амарсанаа	8.9132%	23,100,100
4	Б.Лхагвадорж	24,4201%	63,288,934
5	Д.Даянбилгүүн	24,4201%	63,288,934
6	Ш.Шинэбаяр	24,4201%	63,288,934

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

	ТУЗ-ийн хараат бус гишүүний нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ч.Оргил	17.8264%	23,100,100
2	Ж.Энхтулга	17.8264%	23,100,100
3	А.Цэнгэл	64.3472%	83,383,351

Тус тус санал авч дараах гишүүд ТУЗ-ийн гишүүнд сонгогдов. Үүнд:

Ердийн гишүүнд:

1. Энхболд Батболд
2. Чулуун Энхболд
3. Чулуун Амарсанаа
4. Бүрэнмэнд Лхагвадорж
5. Данзан Даянбилгүүн
6. Шараа Шинэбаяр

Хараат бус гишүүнд:

1. Чулуунбаатар Оргил
2. Жаргалсайхан Энхтулга
3. Алтангэрэл Цэнгэл

11:40 цагт Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан тогтоолын шийдвэрийг танилцуулан дуусч, хурлын дарга хурлыг хаав.

Хурлын дарга: / Ч.Амарсанаа /

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: / С.Ганбат /



Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ЗОРИУЛАВ.

ХУРЛААР ХЭГЭЛЦЭХ АСУУДЛУУД

- 1. Компанийн санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлт*
- 2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан*
- 3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө*
- 4. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт*
- 5. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид*
- 6. ТУЗ-ын 2020 оны цалин урамшууллын төсөв*
- 7. Нөгдөл ашиг тараахгүй тухай шийдвэр*

Хэлэлцэх асуудал 1

Компанийн
санхүүгийн
тайлан, түүнд
хийгдсэн хараат
бус аудитын
дүгнэлт





“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

_____ оны _____ сарын _____ өдөр

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ЭТРАНС ЛОЖИСТИКС” ХХК-ИЙН УДИРДЛАГАД

Бид танай байгууллагын 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Зөрчилгүй дүгнэлт

Танай байгууллага 2019 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн "Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага" хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлсэн билээ. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын холбогдох олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын хүлээх үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана. Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм. Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв. Аудит хийхдээ аудитын горим (Шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болголт, тулгах гэх мэт)-уудыг ашиглав. Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

Тайлангийн зориулалт

Энэхүү тайланг танай байгууллагын хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэв. Бид энэ тайлангийн агуулгын хүрээнд гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Аудиталсан санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав.



Т.СУГАРСҮРЭН

Санхүүгийн байдлын тайлан

	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Мөнгөн хөрөнгө	88,775.7	57,491.2
Дансны авлага	25,000.0	600.0
Татвар, НДШ - ийн авлага	40.1	-
Хангамжийн материал	103,091.5	51,621.8
Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	35,927.0	10,200.0
Эргэлтийн хөрөнгийн дүн	252,834.3	119,913.0
Үндсэн хөрөнгө	4,601,570.1	4,556,235.9
Биет бус хөрөнгө	622,741.9	564,647.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,244,311.9	5,102,883.6
<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>	5,477,146.2	5,222,796.6
<u>Богино хугацаат өр төлбөр</u>		
Дансны өглөг	275,426.9	242,416.4
Татвар, шимтгэлийн өр	40,714.7	19,024.3
Урьдчилж олсон орлого	-	2,100.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	316,141.6	263,540.7
Урт хугацаат зээл	200,000.0	164,000.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	200,000.0	164,000.0
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	516,141.6	427,540.7
<u>Эздийн өмч</u>		
Энгийн хувьцаа	4,260,000.0	4,260,000.0
Нэмж төлөгдсөн капитал	154,000.0	154,000.0
Хуримтлагдсан ашиг	(587,853.5)	(753,602.2)
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	774,858.1	774,858.1
Эзэмшигчдийн өмчийн дүн	4,961,004.6	4,795,255.9
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ БА ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	5,477,146.2	5,222,796.6

Орлого үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	2018 он	2019 он
	мян.төг	мян.төг
Тээвэр зуучийн орлого	561,253.2	712,587.2
Нийт ашиг (алдагдал)	561,253.2	712,587.2
Түрээсийн орлого	44,136.4	44,826.2
Хүүний орлого	91.9	76.8
Бусад орлого	106,031.8	13,249.9
Удирдлагын зардал	919,732.7	893,655.7
Санхүүгийн зардал	12,976.6	32,082.5
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	22.8	9.3
Бусад зардал	(9,317.4)	10,752.3
Татвар төлөхийн өмнөх ашиг	(230,490.6)	(165,741.0)
Орлогын татварын зардал	9.2	7.7
Тайлант үеийн цэвэр ашиг	(230,499.8)	(165,741.0)
Нэгж энгийн хувьцаанд ногдох ашиг, төгрөгөөр	(4.99)	(3.59)

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	789,733.5	977,247.0
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	782,183.5	969,306.5
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	5,713.2	7,930.2
	Бусад мөнгөн орлого	1,836.7	10.3
1.2	Мөнгөн зарлага (-)	762,608.1	835,165.7
	Ажиллагчдад төлсөн	307,892.4	307,998.1
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	38,180.9	45,136.0
	Бараа материал худалдан авахад төлсөн	128,847.4	147,967.0
	Ашиглалтын зардалд төлсөн	71,233.7	86,733.6
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	77,824.4	76,266.2
	Хүүний төлбөрт төлсөн	15,601.7	32,082.5
	Татварын байгууллагад төлсөн	84,218.8	118,322.3
	Даатгалын төлбөрт төлсөн	249.9	2,870.5
	Бусад мөнгөн зарлага	38,558.9	17,789.5

1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	27,125.3	142,081.3
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	291.9	37,550.2
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		10,410.4
	Хүлээн авсан хүүний орлого	91.9	75.7
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	200.0	27,064.0
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	37,711.3	61,813.4
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	37,711.3	59,749.4
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		2,064.0
2.3	Гүйлгээний дүн	(38,003.2)	(24,263.2)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	279,384.00	30,350.7
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	279,384.0	30,350.7
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	183,239.4	179,453.3
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	183,239.4	179,453.3
3.3	Гүйлгээний дүн	462,623.4	(149,102.6)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	85,850.5	(31,284.5)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,925.2	88,775.7
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,775.7	57,491.2

Үндсэн үйлчилгээний орлого

№	Орлогын төрөл	Дүн, мян.төг
1	Шилжүүлэн ачилтын орлого	93,359.5
2	Буултын орлого	1,200.0
3	Хадгалалтын орлого	270,986.3
4	Нэвтрэх үнэмлэхний орлого	237,353.4
5	Бусад орлого	109,688.0
Дүн		712,587.2

Бусад орлого

№	Орлогын төрөл	Дүн, мян.төг
1	Түрээсийн орлого	44,826.3
2	Цайны газрын орлого	13,249.9
3	Хүүний орлого	76.8
4	Гадаад валютын ханшны зөрүүний олз	9.3
Дүн		58,162.3

Удирдлагын зардал

№	Зардлын нэр	2018 он	2019 он
		мян.төг	мян.төг
1	Цалингийн зардал	291,895.6	326,304.9
2	<i>Нийгмийн даатгалын шимтгэл</i>	38,140.8	45,219.5
3	Сэлбэг, засвар үйлчилгээний зардал	10,638.5	12,306.7
4	Ашиглалтын (цахилгаан, дулаан, ус, холбоо, дохиолол, зам арчилгаа)	70,835.8	91,505.0
5	Сургалтын зардал	945.0	180.0
6	Албан томилолтын зардал	12,057.0	1,216.4
7	Харуул хамгаалалтын зардал	-	-
8	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	279,877.7	278,070.8
9	Мэргэжлийн үйлчилгээний зардал	9,052.4	9,099.8
10	Шатахууны зардал	60,931.3	51,414.4
11	Бичиг хэргийн зардал	2,334.4	6,735.5
12	Хангамжийн материалын зардал (хан/мат, ариун цэвэр, аж ахуй дотоод хэрэгцээ)	14,604.6	49,247.6
13	Түрээсийн зардал	-	-
14	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	28,777.6	18,390.1
15	Хөдөлмөр хамгааллын зардал	8,814.9	3,870.1
16	Бусад зардал	90,826.9	94.8
	БҮГД	919,732.7	893,655.7

Бусад зардал

№	ЗАРДЛЫН НЭР	Дүн, мян.төг
1	Ажилчдад нэг удаагийн тусламж	2,481.8
2	Хүү, торгуулийн зардал	593.2
	Сум орон нутгийг дэмжих хандивын зардал	2,800.0
3	Бусад хандив, тусламж	4,877.3
	Дүн	10,752.3

Богино хугацаат өр төлбөр

№	Харилцагчийн нэр	Тайлбар	Дүн, мян.төг
1	Чулуун-Эрдэнэс ХХК	КАТ УНИВЕРСАЛ ТРАКТОРЫН ТҮРЭЭС	18,764.2
2	Ч.АМАРСАНАА	Зээл	175,318.0
3	ДАРДАН ЛОЖИСТИКС ХХК	Зээл	5,200.0
4	Э-ТРАНС ХХК	Зээл	11,441.5
5	Нийслэл-Аудит ХХК	Аудитын хөлс	2,000.0
6	МЦЦТ ХХК	Хоорондын тооцоо	25,380.0
7	Одкон холдинг ХХК	Урьдчилж орсон орлого	2,100.0
8	Тэ Хуа		4,312.5
9	ЗАМЫН-ҮҮД ТАТВАРЫН ХЭЛТЭС	ХХОАТ-н өр	1,729.8
10	ЗАМЫН-ҮҮД ТАТВАРЫН ХЭЛТЭС	НӨАТ-ын өр	17,289.4
11	Бусад	ААНОАТ-ын өр	5.1
	Дүн		263,540.7

Урт хугацаат өр төлбөр

№	Харилцагчийн нэр	Тайлбар	Дүн, мян.төг
1	Худалдаа хөгжлийн БАНК	Урт хугацаат зээл	164,000.0
	БҮГД		164,000.0

Нэгж хувьцаанд ногдох ашиг

№	Үзүүлэлтүүд	Дүн, мян.төг
1	2019 оны цэвэр алдагдал	(165,741,043.8)
2	Энгийн хувьцааны тоо (ширхэг)	46,200,000
3	Нэгж хувьцаанд ногдох алдагдал	(3,587.47)




Хэлэлцэх асуудал 2

Компанийн 2019 оны
үйл ажиллагааны
тайлан

Ачилтыг төрлөөр нь харуулсан нь/ сараар /

Сар	Барилгын төрөл бүрийн материал	Кран	Модон материал	Бусад	Нийт
1.	24	1	12	5	43
2.	6		2		8
3.	27	3	11	6	42
4.	33	5	19	9	71
5.	59	2	11	13	85
6.	45	13	3	20	82
7.	34	12	5	7	58
8.	27	3	10	8	48
9.	28	3	2	10	43
10.	13			3	16
11.	14	1	2	5	22
12.	15		25	5	42
Нийт	325	43	102	91	560

2017-2019 онуудын ачилтыг харьцуулж харуулсан нь



Замын-Үүд боомтын өргөтгөлийн ажил хийгдэж боомтод гаалийн бүрдүүлэлт хийгдэж байсан зарим төрлийн ачаа барааг тус компанийн гаалийн хяналтын бүс рүү шилжүүлсэн нь бусад үйлчилгээ нэмэгдэхэд тодорхой хэмжээнд нөлөөлсөн боловч компанийн удирдлагаас холбогдох байгууллагатай хамтран өмнөх жилүүдэд эхлүүлсэн экспортын ачаа барааг тус хяналтын бүсээр дамжуулан гаргаж жин тонныг баталгаажуулах, хяналт шалгалтыг нэг цэг дээр төвлөрүүлэхээр хийгдсэн ажлын үр дүн мөн энэ өсөлтөнд нөлөөлсөн гэж үзэж болно.


2017, 2018 онд орлогын тодорхой хувийг эзэлж байсан чингэлэг буулгах үйлчилгээ нь машин импортолж байгаа иргэн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанаас шалтгаалан 2 дахин буурсан.

Он	Экспортын ачааны тоо		Пүүлсэн үйлчилгээний хураамж	
	2018 он	2019 он	2018 он	2019 он
1 сар	60	147	1,090,909	2,672,727.27
2 сар	25	36	454,545	654,545.54
3 сар	120	102	2,181,818	1,854,545.45
4 сар	150	154	2,272,273	2,800,000.00
5 сар	160	170	2,909,091	3,090,909.09
6 сар	80	144	1,454,545	2,618,181.82
7 сар	85	181	1,545,454	3,290,909.09
8 сар	201	214	3,654,545	3,890,909.09
9 сар	234	176	4,254,545	3,200,000.00
10 сар	284	456	5,163,636	8,290,909.09
11 сар	321	249	5,836,364	4,527,272.73
12 сар	336	526	6,109,091	9,563,636.36
Нийт	2056	2555	37,381,818	46,454,545.45

Он	Импортоор орж ирсэн чингэлэгийн тоо		Тээврийн хэрэгсэл буулгах үйлчилгээний хураамж	
	2018 он	2019 он	2018 он	2019 он
1 сар	-	8	-	1,454,545
2 сар	2	5	363,636	909,091
3 сар	5	5	909,091	909,091
4 сар	2	3	363,636	545,454
5 сар	10	8	1,818,182	1,454,545
6 сар	20	5	3,636,364	909,091
7 сар	6	8	1,090,909	1,454,545
8 сар	13	3	2,363,636	545,455
9 сар	15	3	2,727,273	545,455
10 сар	13	3	2,363,636	545,455
11 сар	8	1	1,454,545	181,818
12 сар	9	0	1,636,364	0
Нийт	103	52	18,727,273	9,454,544.27

Гаалийн хяналтийн бүсийн үйл ажиллагаа

Сар	Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл		Хяналтын бүс болон агуулахад ачаа бараа хадгалсны хураамж
	Тоо	Хураамж	
1 сар	667	8,422.70	38,888.00
2 сар	235	6,891.10	8,660.00
3 сар	1003	12,729.10	20,408.00
4 сар	1250	25,585.90	8,202.00
5 сар	1763	26,592.70	14,086.90
6 сар	1658	34,125.50	59,585.00
7 сар	1283	18,789.10	3,162.30
8 сар	1464	24,450.00	8,430.80
9 сар	1378	21,816.40	-
10 сар	1136	26,963.60	16,429.60
11 сар	758	23,125.50	11,554.00
12 сар	520	7,861.80	64,060.10
Нийт дүн	13115	237,353.40	253,436.70




Орлогыг нэр төрлөөр нь харуулсан нь /мян.төг /

д/д	Орлогын нэр	2018 он	2019 он	Зөрүү	Өсөлт/ бууралт/
1	Ачилтын орлого	168,949.82	89,620.2	-79,329.62	-47% буурсан
2	Буултын орлого	320.00	1,200.0	880.00	2 дахин өссөн
3	Хадгалалт болон гарах хуудас	325,964.91	490,790.1	164,825.19	33% өссөн
4	Түрээсийн орлого	44,136.36	45,772.7	1,636.34	3,5% өссөн
5	Бусад орлого	171,350.27	264,231.9	92,881.63	35% өссөн

Хэлэлцэх асуудал 3

Компанийн 2020
оны үйл
ажиллагааны
ТӨЛӨВЛӨГӨӨ



д/д	Хийгдэх ажил	2020 он											
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
9	Хяналтын камер, гэрэлтүүлгийн суурийн өндөрлөгөө төмрийг будах				+								
10	Агуулах, граш, төв офиссын байрны урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэх						+	+					
11	Бохирын цооногийг засварлах							+	+	+	+		
12	Нэгдсэн ариутгал, халдваргүйжуулалт хийх			+	+								
13	Контейнер болон бусад төрлийн хүнд даацын ачаа ачиж буулгах техник хэрэгслийг салбар замд байрлуулах боломж, тооцоо судалгаа гаргах							+	+	+			
14	Ачиж буулгах цогцолборын техник хэрэгслийн шинэчлэлтийг судлах							+	+	+			
15	Хэрэглэгчдэд үзүүлж байгаа үйлчилгээгээ өргөжүүлэхийн тулд Банк бус санхүүгийн байгууллагатай хамтарч ажиллах боломжийг судлах				+	+	+						
16	Төлөвлөгөөгөөр ажил хэрэг болох боломжтой ажлуудын тооцоо судалгааг хийж хэрхэн хийж гүйцэтгэх талаар төлөвлөж ТУЗ-д танилцуулах				+	+							
17	Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ын хурлаар шийдүүлэх асуудлыг боловсруулах												+

Улаанаар тэмдэглэсэн нь төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тайлан, төлөвлөгөөг хэлэлцэхэд төлөвлөгөөнд нэмж тусгагдсан заалт

Орлогын Төлөвлөгөө

Мян.төг	2020 оны борлуулалт, ашгийн төлөвлөгөө
Нийт үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого	842,586.57
Ачилтын орлого	/шилжүүлэн ачилтын орлогыг өмнөх оноос 5% өсөхөөр төлөвлөсөн/ 94,100.16
Буултын орлого	/2019-12 сарын байдлаар экспортод гарах ачааны гэрээ хийгдээгүй тул тус үйлчилгээний орлогыг тооцоолоогүй/ 0.0
Хадгалалтын орлого	237,353.4
Баталгаат агуулахын орлого	380,154.95
Бусад үйлчилгээний орлого	130,978.06
Нийт туслах үйл ажиллагааны орлого	178,450.9
Түрээсийн орлого	45,272.7
Хүүний орлого	
Бусад орлого	/Цайны газрын орлогыг 2019 он-с бууруулахгүйгээр төлөвлөсөн/ 133,178.2
<i>Нийт зардал</i>	838,443.0
Ерөнхий ба удирдлагын зардал	811,277.0
Санхүүгийн зардал	27,166.0
Гадаад валютын ханшийн зөрөөний олз/гарз	0.0
Бусад зардал	0.0
Татварын өмнөх ашиг	182,594.47
Татварын зардал /10%/	18,259.45
Татварын дараах ашиг	164,335.02



Хэлэлцэх асуудал 4

Компанийн 2019 оны
үйл ажиллагааны
тайлан болон
санхүүгийн
тайлангийн талаар
төлөөлөн удирдах
зөвлөлийн гаргасан
дүгнэлт

**КОМПАНИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГАРГАСАН ДҮГНЭЛТ**

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн тайлангийн талаар хэлэлцэж дараах дүгнэлтийг өгөв.

Э-Транс логистикс хувьцаат компани нь 2019 оны байдлаар 165,741.0 мянган төгрөгний алдагдалтай ажиллажээ. Энэ нь өмнөх оныхоо мөн үетэй харьцуулбал (230,499,775.3) 64,758,775 мянган төгрөгөөр буюу 39 хувиар буурсан байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтын байдал зарим тодорхой шалтгаануудын улмаас өмнөх оныхоос 2 дахин буурсан байгаа нь (2018 онд 956 вагон, 2019 онд 560 вагон) алдагдал үүсэхэд тодорхой хувиар нөлөөлсөн гэж гүйцэтгэх удирдлагаас гаргасан тайлан мэдээнд дурдажээ.

Үндсэн үйл ажиллагааг сайжруулах, харилцагч татах, бусад төрлийн ачаа барааг шилжүүлэн ачих боломжийг судлах талаар гүйцэтгэх удирдлагын зүгээс зарим ажлуудыг хийж гүйцэтгэсэн, яриа хэлэлцээрийн шатанд байгаа талаар Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан тэдний ажлыг дэмжин ажиллаж байгаа боловч төмөр замын байгууллагын монополь байдал буюу төмөр замтай холбоотой зарим шалтгаануудаас үндсэн үйл ажиллагаа доголдоход нөлөөлсөн гэж дүгнэж болно.

2019 оны 09 дүгээр сарын 09-нд компанийн үндсэн үйл ажиллагаа явагдаж байгаа Дорноговь аймгийн Замын-Үүд суманд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал зохион байгуулагдахад нурмаг ачаа шилжүүлэн ачих боломж нөхцлийг судлах талаар ярилцсан бөгөөд тус компанийн удирдлага энэ тал дээр зарим ажлуудыг хийж гүйцэтгэн bigbag (том уутанд савлагдсан) нурмаг ачааг машинаас машинд шилжүүлэн ачих гэрээ хийж үйл ажиллагаа нь эхэлсэн байсан нь сайшаалттай ажил болжээ гэж үзэж байна. (Гэхдээ энэ ажил улс орны хэмжээнд үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан зогсонги байдалтай болсон байна.)

Үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтын орлого өмнөх оныхоос 47%-иар буурсан үзүүлэлттэй байгаа боловч бусад үйл ажиллагаанаас олох орлого өмнөх жилийнхээс 260,223.16 төгрөгөөр нэмэгдсэн нь нийт алдагдал өмнөх оныхоос буурахад мөн нөлөөлсөн нь бусад үйл ажиллагааг сайн зохион байгуулсан нь харагдаж байна. Гаалийн хяналтын бүсэд 2018 онд 10528, 2019 онд 13115 тээврийн хэрэгсэл нэвтэрч энэ үйлчилгээнээс хурааж байгаа үйлчилгээний хураамж өмнөх оныхоос 75,406.90 төгрөгөөр нэмэгдсэн нь хяналтын бүсийн үйл ажиллагаа ихээхэн ачаалалттай сайн ажилласан нь харагдаж байна. (2016 онд 5967, 2017 онд 8528 тээврийн хэрэгсэл нэвтэрч байсан) Ингэж хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл өссөн нь Замын-Үүд боомтын шинэчлэлтийн ажилтай холбоотой хил дээрх

хяналтын бүс ачаа бараа хүлээн авах боломжгүй болж бусад хяналтын бүсэд хуваарилсантай холбоотой өссөн байж болох бөгөөд боомтын шинэчлэл дуусаж ачаа бараа хүлээж авч эхлэх үеэс дахиж буурах нөхцөл байдал үүсэх магадлалтай тул цаашдын ажлыг энэ байдлаар төлөвлөх хэрэгтэй байна.

Гаалийн баталгаат агуулахад ачаа бараа хадгалуулах үйлчилгээний хураамж 253,436.70 төгрөг буюу мөн өмнөх оныхоос 88,718.36 төгрөгөөр өссөн байна. Гаалийн баталгаат агуулахад 2017 онд 20,397,885 төгрөгийн ачаа бараа, 2018 онд 164,718,338 төгрөгийн ачааг хадгалж жил бүр өссөн байгаа нь баталгаат агуулахын үйлчилгээ цаашид сайжирах төлөвтэй байгааг харуулж байна. Энэ байдлаас дүгнэвэл цаашид гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагааг өргөжүүлэх, баталгаат агуулахыг чанарын шаардлагатай хангахуйц байдлаар тохижуулах, тоноглох ажлыг хийж гүйцэтгэх шаардлагатай гэж үзэж байна. Зөвхөн техник, тоног төхөөрөмж түүний сэлбэг хадгалахгүйгээр бүх төрлийн ачаа барааг хадгалах зориулалттай агуулахуудыг ажилд оруулан иргэд, аж ахуйн нэгжид сурталчилснаар агуулахаар үйлчлүүлэх иргэд, аж ахуйн нэгж нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

Эдгээр үндсэн үйл ажиллагаанаас гадна өмнөх жилүүдэд гаалийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн экспортын ачааг компанийн гаалийн хяналтын бүсэд оруулж автопүүнд пүүлж гаргах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр 2555 тээврийн хэрэгсэлд үйлчилгээ үзүүлсэн хураамжнаас 46,454,545 төгрөгийн орлого олсон нь өмнөх үеийнхээс 9,072,727 төгрөгөөр өссөн байна. Гэвч чингэлэг буулгах үйлчилгээнээс олох орлого 50% буурч 9,454,544 төгрөг болсон нь иргэд, аж ахуйн нэгжээс чингэлэгээр оруулж ирж байгаа тээврийн хэрэгсэл буурснаас шалтгаалсан байна. Үүнээс гадна цайны газар болон бусад төрлийн үйлчилгээнээс олсон орлого 35%-иар өссөн нь аудитлагдсан тайлангаас харагдаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс компанийн үйл ажиллагааг сайжруулах, ашиг орлогыг нэмэгдүүлэх үүднээс тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэхийг 2018 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг дүгнэхдээ зөвлөгөөгөөр хүргүүлсэн бөгөөд зөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

1. Компанийн зүгээс хэрэглэгч татах, үйлчлүүлэгчийг нэмэгдүүлэх талаар компаниар өмнө нь үйлчлүүлж байсан болон одоо үйлчлүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгч нартай уулзалт зохион байгуулж тулгамдаад байгаа нөхцөл байдлыг танилцуулж үйлчилгээний чанар хүртээмжийг харилцагч нар түлхүү хүргэх, давуу эрх олгох боломжийн талаар хэлэлцүүлж ажилласан байна.

Тус хэлэлцүүлэгт 35 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон бөгөөд Кнауфгипс ХХК, Мон-эгг ХХК, Пирамид өргөө ХХК, Дриймвиннер ХХК, Итгэлт буухиа ХХК, ЗМЕН ХХК, Аз буяны цээл ХХК, БАУПЛЮС ХХК, Баялаг фийд ХХК зэрэг 25 иргэн, компаниуд тус компаниар үйлчилгээ авч байхаар тохиролцож хамтран ажиллахаар болжээ.

2. Мөн тус компанийн салбар замд ES bi logistiks компани нь ачаатйа болон хоосон вагон оруулж ирж хадгалуулахаар гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд салбар замыг түрээсээр ажиллуулах талаар зарим аж ахуйн нэгжээс ирж танилцан тооцоо судалгааныхаа ажлыг хийж байна.

3. Үйлчилгээний төвийн ажлыг зохион байгуулахаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу ажлууд зохион байгуулахаар болсон боловч тус компанийн үйл ажиллагаа явуулдаг Замын-Үүд суманд " Номин ", " Сансар " зэрэг сүлжээ дэлгүүрүүд үйл ажиллагаа явуулахаар барилгын ажлыг эхэлсэн байсан тул энэхүү төслийг зогсоосон.

4. Компанийн хяналтын бүсийг стандартын шаардлагад нийцүүлэх, тэнд ажиллагсдын эрүүл, аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс хуучин боомтын талбайд ашиглагдаж байсан даацын хавтанг ашиглан хяналтын бүс орох хэсгээс автопүү хүртэлх газарт хавтангаар зам тавьж ашиглалтанд оруулж энэ ажилд 63 сая төгрөг зарцуулсан бөгөөд 2020 онд энэхүү ажлыг үргэлжлүүлэн зарим талбайг бетонодохоор төлөвлөн ажиллаж байна.

5. Компанийн орлогод тодорхой хувь нэмэр оруулж байгаа цайны газрын ажилчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, түүгээр үйлчлүүлж байгаа иргэдийн тав тухтай үйлчлүүлэх нөхлийг хангаж үйлчлүүлэгч нарын тоог нэмэгдүүлснээр ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор цайны газрын өргөтгөлийн ажлыг 18,087,440 төгрөгийн ажил хийсэн ба одоо мөн төдий тооны дүнтэй засвар үйлчилгээний ажил хийгдэхээр төлөвлөгдсөн байна.

Компанийн орлого үндсэн үйл ажиллагаанаас бусад үйлчилгээнүүдэд дээр дурьдсанаар өссөн байгаа боловч зардлын хэмжээ 2018 оны мөн үеийнхээс дорвитой буурсан үзүүлэлт харагдахгүй байна. Аудитын дүгнэлтээр нийт 893,655.7 мянган төгрөгийн зардал гарсан нь өмнөх оныхоос 26,077.0 мянган төгрөгөөр л буурчээ. Зардлыг бууруулах чиглэлээр цаашид тодорхой ажил зохион байгуулах, бичиг хэргийн хангамжийн материалын, ашиглалтын, сэлбэг, засвар үйлчилгээний болон бусад шаардлагагүй зардлууд зэрэг бууруулах боломжтой зардлыг бууруулах боломжтой гэж үзэж энэ чиглэлийг барьж ажиллахыг зөвлөж байна.

Мөн компанийн гүйцэтгэх удирдлагад компанийн урт болон богино хугацааны бизнесийн төлөвлөгөөг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж мөрдөж ажиллах талаар зөвлөмжийг хүргүүлсэн боловч уг төлөвлөгөөг боловсруулах явдал удааширалтай байсан бөгөөд 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлснийг хэлэлцэн баталсан.

Цаашид компанийн үйл ажиллагааг хэрхэн зөв зохион байгуулалттай, ашигтай ажиллуулж хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хүртээхэд чиглэсэн урт болон богино хугацааны бизнес төлөвлөгөө, менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлж ажиллахыг дахин зөвлөж дээрх төлөвлөгөөг 2020 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болголоо.

Эцэст нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2019 оны үйл ажиллагаа алдагдалтай байсан боловч алдагдалын хэмжээ өмнөх оныхоос буурсан үзүүлэлттэй байгаа нь сайшаалттай байгаа боловч цаашид алдагдалгүй ажиллахад чиглэсэн бүхий л боломжтой ажлуудыг хийх, энэхүү дүгнэлтээр өгсөн зөвлөмж, үүргүүдийн дагуу тодорхой ажлуудыг төлөвлөн, төлөвлөгөөний дагуу хийсэн ажлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд байнга танилцуулж, холбоотой ажиллаж байхыг гүйцэтгэх удирдлагад өгсөн энэхүү дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хэлэлцэх асуудал 5

ТУЗ-ийн ердийн
болон хараат бус
гишүүнд нэр
дэвшигчид



**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч
Чулууны Энхболдын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулууны Энхболд
Төрсөн он: 1967 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК-ийн ерөнхий захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Төв аймгийн Зуунмод хотын 10 жилийн сургууль	Бүрэн дунд	1974	1984
2	Ленинградын Төмөр замын дээд сургууль		1984	1989
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

3. Ажлын туршлага

1989-1990 онд УБТЗ-ын өртөө ажилчин

1990-1992 онд УБТЗ-ын Замын –Үүд өртөө орлогч дарга

1992-1994 онд УБТЗ-ын Багануур өртөө орлогч дарга

1992-1997 онд ТУУШИН ХХК ОУ-ын тээвэр зууч, экспортын тээвэрлэлтийн мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч
Чулууны Амарсанаагийн тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулууны Амарсанаа

Төрсөн он: 1961 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс Ложистикс ХХК гүйцэтгэх захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1969	1979
2	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль		1979	1984
3	БНСЧС улсын Коопщинице мэргэжил дээшлүүлсэн		1989	1990

3. Ажлын туршлага

1984-1985 онд Бугантын алтны үйлдвэрт засварчин, туслах эксваторчин

1985-1991 онд Цагаан дэлийн уурхай, ерөнхий механик

1991-1995 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэр, Ерөнхий инженер дарга

1995-2002 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэрийн харьяа Хавчуугийн алтны уурхай, ерөнхий инженер дарга

2002-2011 онд Э-Транс ХХК, гүйцэтгэх захирал

2011 оноос Э-Транс Ложистикс ХХК гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч
Энхболдын Батболдын тодорхойлолт**



1. Товч танилцуулга

Овог нэр: Энхболдын Батболд
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК, дэд захирал

2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1995	2004
2	Тайваний их сургууль	Эрх зүйч	2008	2014

3. Ажлын туршлага

2014 онд Тайвань дахь худалдаа эдийн засгийн төлөөлөгчийн газарт туслах ажилтан,
2016 оны 04 сараас Баянцемент ХХК, ерөнхий менежер
2018 оны 06 сараас Э-Транс ХХК, дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч
Данзангийн Даянбилгүүний тодорхойлолт**



1. Товч танилцуулга

Овог нэр: Данзангийн Даянбилгүүн
Төрсөн он: 1976 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: “БиДиСек” ХК, Гүйцэтгэх захирал

2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1984	1994
2	Европ хэлний дээд сургууль	Бизнесийн эдийн засагч	1994	1998
3	СЭЗДСургууль	Бизнесийн удирдлага, магистр	2006	2011

3. Ажлын туршлага

1994-1995 онд Эдийн тэнгэр банк, оператор-нягтлан бодогч
1995-1997 онд Улсын их хурлын тамгын газар, гишүүний орон тооны ажилтан
1997-1999 онд БиДиСек ХК, салбарын менежер
1999 оноос БиДиСек ХК, гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч
Бүрэнмэндийн Лхагвадоржийн тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Бүрэнмэндийн Лхагвадорж

Төрсөн он: 1976 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК, тэргүүн дэд захирал



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1983	1993
2	ШУТИС	Нефтийн инженер	1993	1997

3. Ажлын туршлага

1997 оноос БиДиСек ҮЦК ХК, тэргүүн дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч
Шараагийн Шинэбаярын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Шараагийн Шинэбаяр
Төрсөн он: 1979 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: “ БиДиСек ҮЦК ” ХК-нд менежер



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	Сэрүүлэг дээд сургууль	Бизнесийн удирдлага	2001	2005

3. Ажлын туршлага

2009 оноос “ БиДиСек “ ХК-ны хөрөнгө оруулалтын албанд менежер

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Жаргалсайханы Энхтулгын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Жаргалсайханы Энхтулга

Төрсөн он: 1987 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил:

“ Лайф ис гүүд монголиа ” ХХК, нягтлан бодогч



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Санхүү Эдийн Засгийн дээд сургууль	Бизнесийн удирдлага	2005	2010

3. Ажлын туршлага

2011 онд МҮХАҮТанхим, НБТЗГазар туслах ажилтан

2014-2017 онд “ Лайф ис гүүд монголиа ” ХХК, худалдан авалтын зөвлөх

2017 оноос “ Лайф ис гүүд монголиа ” ХХК, нягтлан бодогч

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Алтангэрэлийн Цэнгэлийн тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Алтангэрэлийн Цэнгэл
Төрсөн он: 1985 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил: хувиараа



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	ШУТИСургуулийн лицей	Бүрэн дунд	2001	2003
2	ИрГУПС	Дээд	2003	2008
3	Нанкай	магистр	2014	2015
4	Удирдлагийн академи	магистр	2012	2018

3. Ажлын туршлага

2008-2013 онд Улаанбаатар төмөр зам,
2013-2015 онд Ти Ай ложистик ХХК, дэд
2015-2017 онд Рэйлнет ХХК, дэд

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч
Чулуунбаатарын Оргилын тодорхойлолт**

1. Товч танилцуулга

Овог нэр: Чулуунбаатарын Оргил
Төрсөн он: 1987 он
Иргэний харьяалал: Монгол
Эрхэлж байгаа ажил:



2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын 1-р сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Хан-Уул Дээд сургууль	Бизнесийн удирдлага	2005	2010
3	Хан-Уул Дээд сургууль	Программ хангамж	2005	2011
4	Chinese Culture University	Мэдээллийн удирдлагын систем, Магистр	2012	2013

3. Ажлын туршлага

2015-2016 онд ҮАБЗөвлөл-ССХ-д мэргэжилтэн,
2017-2019 онд БНЭУлсын Элчин сайдын яам маркетингийн албаны дарга

Хэлэлцэх асуудал 6

Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2020 оны
цалин урамшуулалын
төсөв



	Зардлын нэр	Нэгжийн зардал	Зардлын дүн / төгрөг /
1	ТУЗ-ын гишүүдийн цалин	-	-
2	ТУЗ-ын нарийн бичгийн цалин	240,000*4	960,000
3	Зөвлөх үйлчилгээний хөлс	1,000,000	1,000,000
4	ТУЗ-ын хурлын зардал	1,000,000	1,000,000
5	Томилолтын зардал	1,000,000	1,000,000
6	Бичиг хэргийн зардал	100,000	100,000
7	Бусад / ХЭХ-ын зар гаргах /	500,000	500,000
	Дүн		4,560,000



**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020.02.14.

№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.5 дахь заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс эчнээ санал хураалтаар авсан саналын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Э-Транс Ложистикс" ХК-ны 2019 оны үйл ажиллагаа алдагдалтай гарсан тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Ногдол ашиг хуваарилахгүй болсон үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Гүйцэтгэх захирал Ч. Амарсанаад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Э.БАТБОЛД

Хэлэлцэх асуудал 7

Ногдол ашиг
тараахгүй талаарх
шийдвэр



Анхаарал Тавьсанд баярлалаа

Хувьцаа эзэмшигчдэд зориулав.

2020 он